

БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, БНХАУ-ын Боловсролын яам хоорондын боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу жил бүр тодорхой тооны Монгол оюутнуудыг бакалаврын зэрэгт БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцуулдаг.

Нэг. Тавигдах шаардлага

1. Монгол Улсын иргэн байх, эрүүл байх

2. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын гэрчилгээтэй, сурлагын дүн сайтай

3. Хүсэлт гаргагч нь хүсэлт гаргасан тухайн сургуультайгаа урьдчилан холбогдож суралцах мэргэжил болон суралцах хэлээ урьдчилж тодорхойлсон байх шаардлагатай.

- Хятад хэл дээр суралцах бол HSK3 болон түүнээс дээш төвшний мэдлэгтэй байх

4. Тэтгэлгээр суралцагчид Хятадын Засгийн газраас тогтоосон бүх шатны бусад тэтгэлэг, элсэлтийн байгууллагуудаас нэгэн зэрэг санхүүжилт авахыг хориглоно. Санхүүжилтээ зориудаар нуун дарагдуулсан тохиолдолд Хятадын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдах эрхийг цуцалж, Хятадын Засгийн газрын тэтгэлгээр суралцах эрхийг хасна.

Хоёр. Бүртгэл

Хүсэлт гаргагч нь Хятадын гадаад оюутнуудын веб сайт <http://www.campuschina.org> –д бүртгүүлж, материалаа илгээх шаардлагатай.

Бүрдүүлэх материал:

1. "БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маяг"-ыг (Хятад эсхүл Англи хэл дээр бөглөнө);

2. Гадаад паспортын эхний нүүр хуудас

Жич: Хүсэлт гаргагчийн гадаад паспортны хугацаа хүчин төгөлдөр байх шаардлагатай. Гадаад паспортын эхний нүүр хуудасны сканердсан тод хуулбарыг илгээнэ.

3. Боловсролын зэргийн гэрчилгээ (Нотариатаар баталгаажуулсан байх)

Хүсэлт гаргагч нь өөрийн сурч буй эсвэл төгссөн сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ эсхүл элсэлтийн гэрчилгээг илгээнэ

4. Дүнгийн хуулбар

Бүх бичиг баримтыг хятад эсхүл англи хэл дээр орчуулан нотариатаар батлуулан эх хувийн хамт хавсаргах

5. HSK, IELTS эсвэл TOEFL-ийн шалгалтын дүнгийн хуудас

- Хятад хэл дээр суралцах бол HSK-ийн хүчинтэй оноотой байх;

- Англи хэл дээр суралцах бол IELTS эсвэл TOEFL-ийн шалгалтын дүнгийн хуудсыг бүрдүүлж өгөх;

7.Суралцах төлөвлөгөө

200-аас багагүй үгтэй (хятад эсвэл англи хэлээр бичнэ) байх;

8.Хоёр тодорхойлох захидал

Өөрийгөө хамгийн сайн тодорхойлж чадах 2 багшийн тодорхойлох захидлыг авч Англи эсвэл Хятад хэл дээр орчуулан нотариатаар батлуулсан байх хэрэгтэй

9.Ур чадварын бүтээл

Урлаг, дизайн гэх мэт мэргэжлээр суралцах хүсэлтэй хүмүүс "Бүтээл /бусад туслах материал"-аар дамжуулан ур чадварын бүтээл (зураг, хар зураг гэх мэт) байршуулна;

10.Хүсэлт гаргагч нь 18 нас хүрээгүй бол Хятад дахь хууль ёсны асран хамгаалагчийн холбогдох хууль ёсны баримт бичгийг бүрдүүлэх

11."Гадаад иргэдийн эрүүл мэндийн шинжилгээний хуудас"-ыг бөглөн ирүүлэх

Жич: Эх хувийг өөртөө хадгалах ба энэ маягыг Хятадын Эрүүл мэнд, хорио цээрийн газраас нэгдсэн журмаар хэвлэсэн байдаг бөгөөд англи хэл дээр бөглөнө). "Гадаадын иргэдийн эрүүл мэндийн шинжилгээний хуудас"-д заасан заалтыг чанд баримтлах шаардлагатай. "Гадаад иргэдийн эрүүл мэндийн шинжилгээний хуудас" дутуу, тухайн хүний зураг байхгүй, зурган дээр тамга дараагүй, эмч, эмнэлгийн гарын үсэг, тамга тэмдэггүй байвал хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Уг шинжилгээний хуудас нь 6 сарын хугацаанд хүчинтэй байх ёстой.

12.Цагдаагийн тодорхойлолт

Өргөдөл гаргагч нь тухайн орон нутгийн Цагдаагийн газраас олгосон гэмт хэргийн бүртгэлгүй, ял шийтгэлгүй нь үнэн болох тодорхойлолт ирүүлнэ. Хүсэлт гаргахаас өмнөх 6 сарын доторх тодорхойлт байх;

Гурав. Бичгийн шалгалт, ярилцлага

Жил бүр тогтсон цаг хугацаанд БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас тогтсон цагт бичгийн шалгалт, ярилцлагыг зохион байгуулна. Шалгалтын тухай мэдэгдлийг цаг тухайд нь мэдэгдэх тул хүсэлт гаргахдаа холбоо барих хаягаа үнэн зөв бөглөнө үү. Шаардлага хангаагүй материал ирүүлсэн хүмүүсийг шалгалтад оролцдоггүй болохыг анхаарна уу!

Дөрөв. Нэн тэргүүнд тавигдах элсэлтийн мэргэжлийн тухай

Тэтгэлэгт хамрагдах элсэгчдийн сурлагын чанарыг дээшлүүлэх, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 70 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцуулах болно.

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ